

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2020.12.25-2020.01.24/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын Засаг даргын 2019 оны 12-р сарын 04-ний өдрийн А/173 дугаар Захирамжаар 2019 оны жилийн эцсийн хүн ам, мал тооллогын ажлыг зохион байгуулах комисс томилогдон ажилласнаар урьдчилсан байдлаар 1089 өрхийн 3603 хүн ам, 55392 толгой мал тоологдоод байна.

Сумын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж албан байгууллагуудын мэдээлэлтэй танилцан байгууллагуудын удирдлагуудад холбогдох чиглэлийн дагуу хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Сумын төв шинэ жилийн баяр наадмыг 2019 оны 12-р сарын 30-ны өдөр 3-р сургуулийн спорт зааланд ёслол төгөлдөр тэмдэглэж сумын “Тэргүүний хамт олон”-оор 1 байгууллага, “Тэргүүний ажилтан”-аар - 2, Сумын Засаг даргын “Баярын бичиг”-ээр – 8 иргэн тус тус шагнагдлаа. Мөн Боржигин чуулгын уран бүтээлчдийн тоглолтыг толилууллаа.

2019 оны сумын “Тэргүүний ажилтан”-аар

1. З.Баасандалай – ЗДТГ-ын Нийгмийн бодлогын мэргэжилтэн
2. Б. Энхбаатар - ШОХК-ийн Технологийн автомашины оператор-жолооч нар шалгарсан бол

Сумын Засаг даргын баярын бичгээр:

1. Ж. Наранцацрал - ЕБС-ийн дотуур байрны багш

2. Ч. Энхтуяа - Эрүүл мэндийн төвийн сувилагч
3. М. Анх-Эрдэнэ - Цагдаагийн хэсгийн жижүүрийн цагдаа
4. Ө. Эрдэнэдалай - Цагдаагийн хэсгийн жижүүрийн цагдаа
5. Г. Оргүйбат - Сумын ахмд настан
6. Ц. Өлзийбуян - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөлийн гишүүн
7. Б. Батбаяр - Бизнес эрхлэгч
8. Б. Батчимэг - Бизнес эрхлэгч нар тус тус шагнагдсан байна.



Сумын Засаг даргын 2019 оны А/105 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг, багийн түр товчоодын ажлын хэсгүүд “Хүн ам орон сууцны тооллогын ажлыг 2020 оны 01-р сарын 09-15-ны хооронд зохион байгуулж сонгогдсон 110 өрхийн 399 иргэнийг бүрэн хамруулсан.



Сумын Засаг даргын 2020 оны 01-р сарын 20-ны өдрийн А/09 дугаар Захирамжаар “Цэргийн бүртгэл явуулах тухай” ажлын хэсэг томилогдон Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг 2020 оны 01-р сарын 20-ноос 02-р сарын 10-ны

хооронд зохион байгуулахаар ажиллаж 01-р сарын 24-ний өдрийн байдлаар 228 иргэн хамрагдаад байна.

Монгол Улсын Засгийн газраас өвөлжилт хүндрэлтэй аймгуудад өвс олгож Шивээговь суманд ирсэн 1000 боодол өвсийг сумын малчин буюу мал бүхий өрхөд тараах ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн зохион байгуулж өнөөдрийн байдлаар 150 иргэнд олгоод байна.



Сумын Засаг даргын зөвлөлийн хурлыг 2020 оны 01-р сарын 23-ны өдөр зохион байгуулж аймгийн “Аварга малчин”-аар Б.Отгонбаатарыг шалгаруулж материалыг аймгийн засаг даргад хүргүүлсэн. Мөн сумын “Аварга малчин” -аар Т.Батболд, Т.Мягмар, Ш.Бадамханд нарыг шалгарууллаа.

ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2019 оны жилийн эцсийн орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 56836,7 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэл 63668,5 мянган төгрөг төвлөрч 112 хувийн биелэлттэй ажилласан байна.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн 2019 оны жилийн эцсийн мэдээг гаргаж ТЗУХ-т хүргүүлсэн. Үүнд:

2019 онд Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт 171 өргөдөл, иргэний бүртгэлийн асуудлаар 448 нийт 619 өргөдөл хүлээн авч 617 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж 2 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Өргөдөл, гомдолын шийдвэрлэлтийн явц 99,7%-тай байна.

Сумын Засаг даргын 2019 оны 12-р сарын 24-ний өдрийн А/192 дугаар захирамжаар 2019 оны 12-р сарын 25 –аас 2020 оны 01-р сарын 02-ны өдөр хүртэл сумын хэмжээний хариуцлагатай жижүүрийн хуваарийг гарган 6 байгууллагын дарга нар байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа, нийгмийн хэв журмыг ханган хяналт тавьж ажилласанд ямар нэгэн зөрчил гараагүй болно.

Сумын малчин буюу мал бүхий иргэдийн хуулийн мэдлэгийг дээшлүүлэх багц сургалтыг зохион байгуулж шинээр батлагдсан болон шинэчлэн өөрчлөгдсөн 6 нэр төрлийн хуулийн сургалт, мэдээллийг 84 иргэнд хүргэн, 13 нэр төрлийн 1000 гаруй гарын авлага сургалтын материалыг тарааж ажилласан. Сургалтын эхэнд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хийгдсэн худалдан авах ажиллагааны тайлан болон 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг танилцуулж, иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулан 84 иргэнээс сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр төсөл, арга хэмжээний саналыг цаасаар авч ажилласан.



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ :

“Хүүхэд хөгжлийн өргөө-Миний гэр” төслийн хүрээнд 2020 оны 01 дүгээр сарын 6-8 өдрүүдэд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын “Мөрөөдлийн сургууль”, Түвдэнгийн Борын нэрэмжит 1 дүгээр сургууль, Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 45, 20 дугаар сургуулиудын үйл ажиллагаатай танилцаж туршлага судаллаа. Үүнд: бага ангийн сургалтын менежер, бага ангийн 5 багш, сургуулийн захирал, нийгмийн ажилтан, дотуур байрны багш, эмч, тогооч зэрэг 12 албан хаагч хамрагдсан.



Шивээговь сумын ерөнхий боловсролын сургууль 2020 оны 1 дүгээр сарын 13-нд “Суралцагчдын ялгаатай байдлыг харгалзан сургалтыг зохион байгуулах” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж 10 илтгэл тавигдаж 1 дүгээр байранд Мэдээлэл зүйн багш Ж.Баярцэцэг, 2 дугаар байранд МХБУЗ-ын багш Б.Чулуунцэцэг, 3 дугаар байранд МХБУЗ-ын багш А.Шинэбаярын илтгэлүүд 3 дугаар шатанд тус тус шалгарч аймагт зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд оролцож Мэдээлэл зүйн багш Ж.Баярцэцэгийн илтгэл шалгарч Улсын илтгэлийн уралдаанд оролцох эрх авлаа.

3-Р ЦЭЦЭРЛЭГ

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2019 оны 12 сарын 27-ны өдрийн А/435 дугаар Захирамжаар сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн хязгаарлалтыг 2019 оны 12-р сарын 30-аас 2020 оны 1-р сарын 20-ны өдөр хүртэл тогтоосон. 3-р цэцэрлэг 2020 оны 1 сарын 20-ны өдрөөс 9 бүлгэт 220 хүүхдийг хүлээн авсан.

Хязгаарлалт хийгдсэн хугацаанд багш нарын сургалтын ажлыг өрнүүлж ажилласан. Үүнд:

Гэр бүлийн баяр хөөр, хамтаараа хөгжилдөө, МУБИС-ийн СӨБС-ийн сургуульд Бага насны хүүхдийн үнэлгээний арга зүй, Хөдөлгөөн эрүүл мэндийн хичээлийн шинэчлэл, Хүүхэд бүрийн ялгаатай байдалд тохирсон дэмжлэгийг үзүүлэн зураг

урлалын хичээлийг явуулах нь, Сургалтын нэгдмэл арга зүйг туршин хэрэгжүүлэх нь сэдэвт сургалтуудад багш нарыг бүрэн хамруулсан. Мөн МУБИСийн СӨБСийн урлагийн тэнхэмийн багш нарын Хөгжмийн онол, Дуу заах арга зүй, Бага насны хүүхдийг хөгжмийн энгийн зэмсэгээр хөгжимдөж сургах нь, Хөгжимт хөдөлгөөн заах арга зүй сэдвүүдээр сургалтанд тус тус хамрагдсан.



Аймгийн багш нарын дунд явагдсан 2020 оны Эрдэм шинжилгээний бага хуралд хамрагдаж ЗАН-ийн багш Ц.Батчимэг “Бага насны хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан төсөлт тоглоомоор хөгжүүлэх нь” сэдэвт илтгэлээр 3-р байр эзэлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын орчныг сайжруулах зорилгоор “Тэгш хамруулан хамтдаа суралцай” төслийг багш С.Эрдэнэчимэг, Ц.Батчимэг нар бичиж 1.500.000 төгрөгийн тоглоом авах эрхтэй болсон.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Эрүүл мэндийн төвд 55 өвчтөн хэвтэж үүнээс 36-н хүүхэд хэвтэн эмчлүүлж байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнс, эм тарианы хангалт хүрэлцээтэй байна.

Эмнэлгийн үйлчилгээ нь:

- Амбулаторийн үзлэг – 548 томуу-48

- Урьдчилан сэргийлэх –61
- Дуудлага- 203



БНХАУ-аас гарсан шалтгаан тодорхойгүй хатгалгаа өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг албан байгууллагуудад албан тоотоор хүргүүлэн ажилласан. Мөн нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргаж буй Томуу томуу төст өвчний талаарх урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмжийг цахимаар болон мэдээллийн самбар, гарын авлагаар хүргэн ажиллаж байна.

Томуу томуу төс өвчний дэгдэлт нэмэгдсэнтэй холбогдуулан аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалын дагуу ээлжийн эмч нар 08:30-19:00 хүртэл уртасгасан цагаар ажиллаж байна.

СОЁЛЫН ТӨВ

Үндсэн хуулийг эрхэмлэн дээдлэх өдрийг угтаж 2020 оны 01-р сарын 13-ны өдөр иргэдэд шинээр батлагдсан үндсэн хуулийн талаарх мэдээллийг хүргэж, хуультай холбоотой гарын авлага материал тарааж, арга хэмжээнд оролцсон иргэдийн дунд АХА тэмцээн зохион байгууллаа.



"ЭРҮҮЛ БИЕ, ИДЭВХИТЭЙ ХӨДӨЛГӨӨН" уриан дор чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай боломжийг бүрдүүлэх зорилгоор 7 хоног бүрийн Баасан гарагт "Нийтийн цэнгээнт бүжиг"-ийг тогтмол зохион байгуулахаар 2020 оны 01-р сарын 10-ны

өдрөөс эхлүүлээд байна. Цэнгүүний үеэр бүжгийн багш иргэдэд бүжиг зааж, иргэдийн дунд хөгжөөнт тоглоом зохион байгуулан ажилласан.



Малчдын уулзалт өдөрлөгийн үеэр Угийн бичиг, соёлын өвийн талаарх сургалтыг хүргэж М.Хишигдэлгэр гуайн угийн бичгийг хэрхэн хөтлөж байгаа талаар иргэдэд танилцууллаа. Мөн аймгийн Боржигин өв музейн хамт олон явуулын музейн үйлчилгээг үзүүлж боржигин байшинг танилцуулж ажиллалаа.



Улс орныхоо түүх соёл, эх орноороо бахархан хүндлэх үзэл суртал суулгах ажлын хүрээнд Монгол төрийн бэлгэ тэмдэг болсон "Соёмбо"-ыг 3, 5-р ангийн сурагчдыг хуваарийн дагуу хамрууллаа. Энэ үеэр сурагчид Орон нутаг судлах танхим болон аймгийн Боржигин өв музейн зөөврийн музейтэй танилцаж "Боржигин байшин"-г өөрсдийн гараар угсарч үзлээ.



УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 26 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 8 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийлгэсэн.

01-р сард газраа анх удаа өмчилж авч байгаа 8 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. Иргэдээс 34 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2020 ОНЫ 01 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	8				8	3	5
Төрсөн эх	2	8				8		8
Бүртгүүлсэн гэр бүл	3	-				-	-	-
Нас баралт	4	2				2	2	-
Цуцалсан гэр бүл	5	-				-	-	-
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	7				7	5	2
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	-				-	-	-

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС
ОРСОН ОРЛОГО

2020.01.24.

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2020 оны 01-р сар			Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 300200022101	Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд		

		тоот дансанд						
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Нийслэлээс шилжин ирсэн	5000	2	10000	1000	2	2000	
2	Өөр аймгаас шилжин ирсэн	2500	3	7500	1000	3	3000	
Дүн		17500		5000				
д/д	Үйлчилгээний нэр төрөл	Үйлчилгээний хураамж 300200022130 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд		Бүгд	Тайлбар
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
3	Иргэний үнэмлэх	15000	8	120000	3300	8	26400	
Дүн		120000		26400				
Нийлбэр дүн		137500		31400				
Нийт орлогын дүн				168900				

МАЛ ЭМНЭЛЭГ, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСАГ

Шинэ жилийн баярыг тохиолдуулан суманд үйл ажиллагаа явуулж буй 16 хүнсний дэлгүүр, лангуу, хоолны газруудад хяналт шалгалтыг 2019 оны 12-р сарын 26,27-ны өдрүүдэд зохион байгуулж хугацаа дууссан, хаяг шошгогүй 15 нэр төрлийн 63ш бараа бүтээгдэхүүнийг устгалд оруулахаар хураан авсан.



Малын шилжилт хөдөлгөөний хувьд:

Манай сумаас гадны аймаг, сумдад отроор 27 өрхийн 7464 толгой мал оторлож байна. Манай суманд гадны аймаг, сумдын 6 өрхийн 2944 толгой мал отроор орж ирсэн байна. Сумын бэлчээрийн даац хүрэлцэхгүй байгаа тул отроор орж ирсэн өрхүүдийг отрын бүс нутагт нүүлгэн шилжүүлэх үүрэг даалгавар өгсөн.

1, 2-Р БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАР

Сумын 1, 2-р багийн хурлыг 2020 оны 01 дүгээр сарын 15, 17-ны өдрүүдэд зохион байгуулж 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг 169 иргэнээс авсан. Мөн энэ үеэр сумын Засаг дарга болон багийн Засаг дарга нар 2019 онд хийсэн ажил, 2020 онд хийх ажлаа танилцуулж, шинээр батлагдсан болон шинэчлэн өөрчлөгдсөн хуулиудаар сургалт зохион байгуулсан.



НИЙГМИЙН БОДЛОГО

Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран амны хөндийн үзлэг, эмчилгээг 2020 оны 01 сарын 20-ны өдрөөс 7 хоногийн хугацаанд зохион байгуулахаар ажиллаж 01 сарын 23-ны байдлаар амны хөндийн үзлэгт нийт 1-2 дугаар ангийн 6 бүлгийн 161 сурагч хамрагдаж, 126 сурагч өвчлөлтэй буюу шүдний өвчлөлийн тархалт 78,6%-тай байна. Үүнээс эмчилгээнд хамрагдах шаардлагатай 105 сурагч буюу 83,3% эмчилгээ хийлгэхээс 2020 оны 01 сарын 23-ны өдрийн байдлаар 33%-ийг буюу 39 сурагчийг эмчилгээнд хамруулаад байна.



БАЙГАЛЬ ОРЧИН

Нийтийг хамарсан ажилд сумын хөдөлмөрийн насны ажилгүй 10 иргэнийг түр ажлын байраар ханган 2019 оны 12 дугаар сарын 06-аас эхлэн 10 хоног сумын төвийн зам дагуух модны хашааг сэргээн засварлах, огтоно устгах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгүүлсэн.



Сумын төв хогийн цэгийн хог хаягдлыг түрж дүүрсэн нүхийг булж тэгшилсэн.



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

Сумын Засаг даргын 2019 оны А\134 дугаар захирамжаар золбин нохой, муур устгах ажлын хэсэг томилогдон Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн иргэн Б.Будтай гэрээ байгуулан 2019 оны 12-р сарын 21, 22-ны өдрүүдэд уг ажлыг зохион байгуулж 91 нохой, 4 муурыг устгаж ариутгал халдваргүйжүүлэлт хийж булсан.

Сумын 2020 оны ОНХС-ийн 268,8 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдэх 17 арга хэмжээний төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан Tender.gov.mn, шилэн данс, сангийн яамны сайт, shiveegov.gov.mn зэрэг цахим хуудаст байршуулан иргэдэд мэдээллэн ажилласан.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хогны машин худалдан авах, төв талбайд усан оргилуур байгуулах ажлуудын үнэлгээний хороо байгуулагдаж тендерийн баримт бичгийг боловсруулж байна.

Сум дотор засмал зам тавих ажлын зураг төсөв магадлалын дүгнэлт гаргуулах шатандаа явагдаж байна.

Суманд Цэвэрлэх байгууламж байгуулах зураг төсөв боловсруулах ажил мэргэжилийн байгууллагуудаас зөвшөөрөл авах шатандаа явагдаж байна.

Засаг даргын Тамгын газар